



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 686.

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 41,400,000.00 (дөчин нэгэн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 11,000,000.00 (арван нэгэн сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Шинжлэх ухааны академийн харьяа Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201548

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны / / дүгээр сарын / / ны өдрийн
68... дугаар тогтоолын хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУЛАЛТЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

| Д/д | Автомашины марк, арлын дугаар | Ашиглалтад орсон он | Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/ | Цаашид ашиглах хугацаа (жилээр) |
|-----|--|------------------------|---|---------------------------------------|--|
| 1 | Соната-7, 06-26 УНУ (арал kmheb41aada565967) | 2013 | 41,400,000.00 | 11,000,000.00 | 3 |
| | Нийт дүн | | (дөчин нэгэн сая дөрвөн зуун мянга) | (долоон сая) | |